

АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023.12.04

2023 онд Татварын хэлтсийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг гарган хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2023 онд төрийн захиргааны 3 албан тушаалын сул орон тоо гарсан тул Төрийн албаны тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулах захиалгыг Өвөрхангай аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн.


Тасаг хооронд шилжүүлэн томилуулахаар болон шинээр томилогдсон 8 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулсан.

Шинээр томилогдсон тухайн албан хаагчдаас 30 хоногийн дотор ХАСХОМ-г хүлээн авч, баталгаажуулсан.

Татварын хууль тогтоомжийг сурталчлах, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах ажлын хүрээнд албан ёсны www.tatvar.ov.gov.mn цахим хуудас болон Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс пэйжид 906 мэдээллийг байршуулж 299723 хүн үзэж, 17884 удаа лайк дарж, 6114 удаа шэйрлэж олон нийтэд түгээсэн байна.




Тайлант онд ибаримт аппликейшнаар 375 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч хууль тогтоомжийн дагуу 100 хувь хугацаанд шийдвэрлэсэн.

Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн систем болон татварын удирдлагын нэгдсэн системд 43 албан хаагчийн мэдээллийг бүрэн оруулж, өөрчлөлтийг тухай бүр хийж байна.





Мэдээлийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд зааснаар арга хэмжээг заасан хугацаанд tatvar.ov.gov.mn цахим хуудсанд байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангаж ажилласан.


Авлигатай тэмцэх гэзрээс бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зүрагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг tatvar.ov.gov.mn цахим хуудас болон сурталчилгааны самбарт байршуулж иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.



Төсөв санхүүгийн ил тод байдлын хүрээнд Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн 2023 оны төсөв, 2022 оны төсвийн гүйцэтгэл, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд нь хийсэн аудитын дүгнэлт зэргийг <http://tatvar.ov.gov.mn> сайт болон хэлтсийн мэдээллийн самбарт тавьсан.



Авлигатай тэмцэх газраас санаачилсан "Авлигыг илчилж, шүгэл үлээцгээе! Авлигын эсрэг нэгдье" аянд нэгдэн мэдээллийг байгууллагын албан ёсны пэйж болон вэб сайтад байршуулан олон нийтэд сурталчилсан.



1.1. Миний эхлэн жагсаалт x Facebook x +

facebook.com/UurkhangaiTatvayrnHettes


Search Facebook

Өвөрхангай Татварын хэлтэс
Татвар буй дор төр оршмой

Page - Interest
7032 2615
uvurkhangai@mta.mn
tatvar.ov.gov.mn
Rating - 5.0 (8 Reviews)

Photos See all photos

Өвөрхангай Татварын хэлтэс
2d · 🌐
Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Авлигатай тэмцэх ШШ ажиллагаа"-ны нэг арга хэмжээ болох "Шүтэл ажиллагаа"-ны хүрээнд Авлигын эсрэг үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог анхан хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүтэл үлээхийг **Өвөрхангай Татварын хэлтэс**-ээс уриалж байна. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид эрүүл нийгмийг бүтээхийн төлөө хамтдаа



TATVAR.OV.GOV.MN
Авлигын эсрэг **НЭГДЬЕ** үндэсний хэмжээний нөлөөллийн аянд Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс нэгдэж байна.

You, Bella D Otgoo, Д. Болор-Эрдэнэ and 2 others
2 shares
Like Comment Share

Write a comment...

1.1. Миний эхлэн жагсаалт x Facebook x +


facebook.com/UurkhangaiTatvayrnHettes

Search Facebook

Өвөрхангай Татварын хэлтэс
7032 2615
uvurkhangai@mta.mn
tatvar.ov.gov.mn
Rating - 5.0 (8 Reviews)

Photos See all photos

Өвөрхангай Татварын хэлтэс
2d · 🌐
Авлигын эсрэг аянд Өвөрхангай Татварын хэлтэс нэгдэж байна. Авлигын эсрэг **#Нэгдье**



Монголын Татварын алба
3d · 🌐
Монголын татварын алба Авлигын эсрэг аянд нэгдэж байна. Авлигын эсрэг **#Нэгдье**

You, Д. Болор-Эрдэнэ, Bbto Badamaa and 5 others
3 shares
Like Comment Share

Write a comment...

Facebook


www.facebook.com/UurkhangaiTatvayrnHettes

Search Facebook

Өвөрхангай Татварын хэлтэс
Page - Interest
+976 7032 2615
uvurkhangai@mta.mn
tatvar.ov.gov.mn
Rating - 5.0 (8 Reviews)

Photos See all photos

Өвөрхангай Татварын хэлтэс
17m · 🌐
ТАТВАРЫН ЦАХИМ
ҮЙЛЧИЛГЭЭГ АШИГЛАЖ
АВЛИГЫН ЭСРЭГ НЭГДЬЕ





Авлигын эсрэг тэмцээлд хүн бүрийн оролцоо чухал 110

Монголын Татварын алба
November 24 at 9:17 AM · 🌐
Хөгжил дэвшил, сайн сайхан бүхий төлөө иргэн бүрийн оролцоо чухал бөгөөд өнөөдөр хийсэн зөв үйлдэл тань ирээдүйд ирэх мянга мянган боломжийн эхлэл юм. Авлига... See more

You and Davasuren Tsedenyam

https://www.facebook.com/photo/?fbid=7493749321833&set=a.257279769763587&_ch_101&_ZA2VnYnQqUwHwXWYdFyNzMs5wMwMkKEDJmT7WjEYgXMBbSfomdDfH-phvTn3h5C5F9SkLJk2PZ8_2zCctYWH8U7mF8oRqDZ4hU85g11h_3AreSZUADmco6YvDkgrtjBj8RMMWUWk6A4C2j0mM...



Татварын хэлтсийн “Ил тод байдал” мэдээллийн самбарт Авилгын талаар мэдээ мэдээллийг байршуулж тогтмол шинэчилэн гаргаж мөн бүх тасгуудад Авилгатай тэмцэх газраас ирүүлсэн шторк, сурталчилгаа, зурган мэдээллийг иргэдийн танилцах самбарт байршуулж Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын онцлолт тохируулан зохион байгуулж ажиллалаа.

Ашиг сонирхлын зөрчил болон ил тод байдлын талаарх мэдээллийг хүлээн авах утас: 70323335-ыг ажиллуулж байна.

Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 70321111 гэсэн утсаар мэдээлэл авч байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулж авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх мэдээллийг байршуулсан.




“ЦАХИМААР ҮЙЛЧЛҮҮЛЬЕ” уриатай татвар төлөгчдийн өдрүүдийн хүрээнд Авлигын тухай ойлголт, авлигын талаар 5 удаагийн сургалтыг татвар төлөгчдөд болон ЕБС-ийн сурагчдад зохион байгуулж 152 хүн хамрагдсан. Тус сургалтаар ТЕГ-аас ирүүлсэн Авлигатай холбоотой гарын авлагуудыг тарааж 152 иргэдэд түгээсэн. Мөн Өвөрхангай Татварын хэлтэс цахим хуудсаар мэдээллийг түгээж ажилласан.



Тус хэлтэс нь төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдэх зарчмыг баримтлан ажиллалаа. 2023 онд хувийн хэвшлийн байгууллагатай байгуулсан гэрээ хэлэлцээр байхгүй.


Татварын хэлтсийн Захиргаа, хуулийн тасаг, татварын хэлтсийн дэргэдэх ёс зүйн зөвлөл нь хамтран албан хаагчдад цахимаар "Ашиг сонирхлын зөрчлөөс

урьдчилан сэргийлэх нь", "Ёс зүйн хэм хэмжээг мөрдөх" сэдвээр 2 удаагийн сургалт зохион байгуулан ажилласан.




Ёс зүйн дэд хороо нь **“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ”** хуулийн танилцуулга цахим сургалтыг зохион байгуулж албан хаагчдаас бататгах сорил шалгалтыг авч 36 албан хаагч бүрэн хамрагдав.

Сургалтын сорилын дүнгээр албан хаагчдын дундаж 90,83% үнэлгээтэй дүгнэгдсэн.






Албан тушаалтнуудын 2022 оны Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг бүртгэх, хүлээн авах үйл ажиллагаатай холбоотой Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан цахим сургалтад тус хэлтсийн 40 албан тушаалтныг хамруулсан.



40 албан хаагчдын ХАСХОМ-г хүлээн авахад зөвөлгөө өгч албан хаагч тус бүрийн жимэйл хаягийг программд шивж оруулан бүртгэж, зөвөлгөө өгч ХАСХОМ-ийг цахимаар оруулуулан хянаж баталгаажуулав.

ХАСХОМ -1,2,3 тайланг нэгтгэн ТЕГ-т хугацаанд нь хүргүүлсэн.





ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС